

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХОРИХ ЯЛЫН БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

COMPARATIVE STUDY OF THE POLICY AND IMPLEMENTATION OF PRISON SENTENCE IN SOME FOREIGN COUNTRIES

Б.Мөнхзул

*Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн
ахлах багш, цагдаагийн хошууч*

Товч агуулга: Энэхүү судалгааны ажил нь Арабын Нэгдсэн Эмират, Саудын Араб, Казахстан, Бразил, Шинэ Зеланд, Герман, Австри, Австрали зэрэг улс орнуудын хорих ялын түүхэн хөгжил, бодлого, хорих ялын хэмжээ, үр нөлөөг харьцуулан судалсан болно. Судалгааны үр дүнд улс орнуудын ял шийтгэлийн тогтолцоонд өөр өөр загвар, хууль эрх зүйн онцлог, хүний эрхийн асуудлууд байгааг илрүүлж, Монгол Улсад хорих ялын бодлогыг боловсронгуй болгоход хэрэгжүүлж болох сайн туршлагуудыг тодорхойлсон.

Abstract: This research study compares the historical development, policies, and the extent and effectiveness of prison sentences in countries such as the United Arab Emirates, Saudi Arabia, Kazakhstan, Brazil, New Zealand, Germany, Austria, and Australia. The study identifies different models, legal features, and human rights issues in the penal systems of the countries, and identifies good practices that can be implemented to improve the penal policy in Mongolia.

Түлхүүр үг: Хорих ял, бүх насаар хорих, ялын бодлого үр нөлөө, урьдчилан сэргийлэх бодлого.

Keywords: Imprisonment, life imprisonment, sentencing policy effectiveness, prevention policy.

Үндсэн хэсэг

Английн эрдэмтэн Жереми Бентам, Беккариа нар ял шийтгэлийн зорилго болоод зарчмыг хэд хэдэн байдлаар тодорхойлсон байдаг. Беккариагийн үзсэнээр, гэм буруутай үйлдэл, ял шийтгэлийн харьцаа нь хохирогчийн эд хөрөнгө, сэтгэл санааны хохирлын хэмжээнээс бус нийгэмд үзүүлсэн сөрөг үр нөлөөнд тулгуурлан оногдуулах ёстой байв.¹ Төр эрх мэдлийнхээ хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд гэмт хэргийг хориглох, саатуулахад чиглэсэн хүч хэрэглэх бүрэн эрхтэй ба энэ нь ял шийтгэл юм.

Гэм буруутай үйлдэл бүхэнд өөр өөр ял шийтгэл оногдуулах шаардлагатай. Хүн амын тоо өсөх, нийгмийн хүрээ тэлэхэд гэмт хэрэг, зөрчил нь бусад нийгмийн асуудалтай хамт хүрээгээ тэлдэг хэдий ч эрүүгийн хуульд гэмт хэргийг хэр зэрэг оновчтой ялгаж тодорхойлсон болон үйлдэлд болгонд оногдуулах ял шийтгэлийн төрөл, хэмжээг нийгмийн хор аюулын шинж чанарт тохирсон байдлаар тогтоосноос тухайн улсын эрүүгийн бодлогын үр нөлөө шалтгаална.²

Беккариагийн онолын үндсэн санаа бол “Хүн төрөлхтөн үргэлж өөрийн ашиг хонжоог эрэлхийлж байдаг тул гэм буруутай үйлдэл гаргах нь тодорхой юм. Иймээс “Шийтгэл нь хүнийг

¹ Осман долу . Криминологийн онолууд (Э.Дашгаадан, Орч.). Бэмби сан принтинг. 31х

² Дорждамын Зүмбэрэлхам. Криминологийн онол. Соёмбо принтинг. 15х

тэр л хэмжээ хязгаарт нь барьж байх ерөнхий зорилгыг агуулдаг буюу ял шийтгэл нь үйлдэлд тохирсон байх ёстой”-г тодорхойлжээ.

Сонгодог үзэл баримтлалд ял шийтгэл нь хүнийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хийсэн үйлдэлд нь тохирсон шийтгэл эдлүүлэх зорилготой гэж үздэг байна. Энэ нь гэмт этгээдийг хорьж, нийгмээс тусгаарласнаар нийгмийг хамгаалах зорилгыг бас агуулдаг.

Ял шийтгэлийн онцлог шинжийг ял шийтгэл үр дүнтэй байлгахын тулд Беккариа дараах гурван үндсэн зарчмыг гаргасан юм.

1. Гарцаагүй байх /certainly/
2. Түргэн шуурхай байх /celerity/
3. Тохирсон хэмжээтэй /severity/

Беккариагийн үзэл баримтлалаас дүгнэхэд ял шийтгэл нь гэмт этгээдийг цээрлүүлэхээс гадна гэмт хэрэг үйлдэхээр төлөвлөж буй хүнд саад болох ёстой ба иймийн тулд ял шийтгэл нь нийгэмд учруулсан хор хөнөөлтэй тэнцүү байх ёстой гэж үзсэн байна.³

Өөрөөр хэлбэл, гэмт этгээд болон эрсдэлтэй этгээдийг ухамсарлуулахын тулд үйлдэгдсэн гэмт үйлдэлд тохирсон ял шийтгэл оногдуулах шаардлагатай байдаг эс бөгөөс ял шийтгэл өөрийн үндсэн мөн чанараа алдаж, бусдад ял завших боломжийг олгох юм.⁴ Мөн гэмт хэрэгт тохиромжгүй ял шийтгэл оногдуулах нь нийгэмд үр нөлөөтэй чанарыг алдагдуулна.

Харин Английн эрдэмтэн Жереми Бентам хүмүүсийг зовлонгоос ангижрах болон ашиг хонжоог эрэлхийлж амьдардаг гэж үзэж байв. Энэ үзэл санааг 1789 онд хэвлэгдсэн "Ёс суртахуун ба амьдрах зарчим /An introduction to the Principles of Morals and Legislation/" нэртэй нийтлэлдээ ашгийн зарчмын талаар Бентам хууль болон ял шийтгэлтэй холбон Беккариагийн үзэл санаатай нийцүүлэн шүүн таслах шударга бус тогтолцоог шүүмжилсэн. Бентам гэмт хэрэг, зөрчлийг нийгмийн эсрэг сөрөг үзэгдэл гэж үзэж байсан. Ял шийтгэлийг шууд шийтгэх зорилгоор оногдуулах нь буруу, үндсэн зорилго нь гэмт хэрэг зөрчлөөс сэргийлэх явдал юм.

Бентамын ашгийн зарчмаар /utility principle/ “Ял шийтгэл гэдэг бол өөрөө нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд гэмт этгээд нийгэмд учруулсан гэмт хороос илүү хохирол учруулахаас сэргийлж хэрэглэх арга юм” гэжээ.⁵

Түүний гэмт хэрэг, зөрчлийн ашиг хонжоо, ял шийтгэлийн тооцоогоор бол гэм буруутай үйлдлээс олж авах ашиг хонжоо нь эрсдэл буюу ял шийтгэлтэй тэнцүү байх нь гэмт хэрэг үйлдэх шалтгаан болдог байна. Бентам үүнийг гедонист тооцоо гэж тодорхойлсон ба тухайн үйлдлийн үр дүнд үүсэх ашиг хонжоо болон ял шийтгэл, эрсдэлийг үнэлж, ашиг хонжоо илүү доош татаж байвал гэмт хэрэг үйлдэх магадлалтай, харин ял шийтгэл илүү доош татаж байвал гэмт хэрэг үйлдэхээс татгалзах магадлалтай гэж дүгнэжээ.

Хорих ялын тогтолцоо нь улс орон бүрийн түүх, хууль эрх зүй, шашин, соёлын онцлогтой нягт уялдан хөгжиж иржээ. Судалгаанд хамрагдсан орнуудын жишээгээр авч үзье.

Арабын Нэгдсэн Эмират Улс болон бусад арабын орнууд: АНЭУ нь исламын шариатын хуулийг эрх зүйн үндсэн эх сурвалжаа болгож, гэмт хэргийн шийтгэлд уламжлалт, хатуу арга хэмжээг хэрэглэсээр ирсэн. Түүхэн хөгжлийнхөө явцад

³ Батдуламын Мөнх-Эрдэнэ. Гэмт хэрэг судлалын онол. “Өнгөт талст” принтинг. 47х

⁴ Осман долу . Криминологийн онолууд (Э.Дашгаадан, Орч.). Бэмби сан принтинг. 31х

⁵ Дорждамбын Зүмбэрэлхам. Криминологийн онол. Соёмбо принтинг

бурхны эсрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт Кораныг үндэслэн шийтгэл оногдуулдаг байсан бөгөөд хулгай, залилан зэрэг эдийн засгийн гэмт хэрэгт хорих ялыг өргөн хэрэглэдэг байв. Саудын Араб зэрэг улсад олон нийтийн өмнө шийтгэх, цаазаар авах, ташуурдах зэрэг шийтгэл түүхэн цаг үед түгээмэл байсны зэрэгцээ сүүлийн жилүүдэд зарим эрхийн хязгаарлалт, хүүхэд болон эмэгтэйчүүдэд оноох ялд өөрчлөлт орж байна.

Казахстан Улс: Хувь хүний эрх чөлөөг хязгаарлах болон хорих ялыг хослуулсан тогтолцоог нэвтрүүлсэн бөгөөд хорих ял нь зургаан сараас хорин жил хүртэл, онц хүнд гэмт хэрэгт бүх насаар хорих ял оногдуулж болохоор хуульчилжээ. Эрх чөлөөг хязгаарлах ялыг нийгмээс бүрэн тусгаарлахгүйгээр оршин суугаа газарт нь гүйцэтгэх зэрэг онцлогтойгоор хөгжсөн.

Бразил Улс: Бразилын хорих ялын тогтолцоо нь колоничлолын үеэс улбаатай. Анхны шоронгийн зохион байгуулалт нь католик шашны сахилгын шийтгэлээс үүдэлтэй байсан бөгөөд XIX зуунаас эхлэн бие даасан хорих байгууллагууд бий болж, эрүүгийн хуулиудаа шинэчилснээр бүх насаар хорих ял, энгийн хорих ялыг хуульчилсан. 2019 онд батлагдсан шинэчлэлээр хорих ялын дээд хязгаарыг 30 жилээс 40 жил болгон нэмэгдүүлсэн нь тус улсын нийгмийн нөхцөл, дундаж наслалтад тулгуурласан өөрчлөлт байв.

Шинэ Зеланд Улс: Хорих ял нь 1840-өөд оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 1989 онд цаазаар авах ялыг халснаар хамгийн хүнд гэмт хэрэгт бүх насаар хорих ялыг хэрэглэдэг болсон. 1856 оны Эрүүгийн алба хаах тухай хууль нь шоронгийн ялыг хууль ёсны шийтгэл болгож, ялын тогтолцоог нарийвчлан тогтоох суурийг тавьжээ.

Австри Улс: Австрид XVIII зуунд Ч.Беккариагийн цаазаар авах ялыг бүх насаар албадан ажил хийлгэх ялаар солих онолд тулгуурлан бүх насаар хорих ялыг хэрэглэж эхэлсэн. XIX зууны эхнээс хугацаатай хорих ялыг ял шийтгэлийн бие даасан төрөл болгон хөгжүүлсэн бөгөөд 20 нас хүрээгүй этгээдэд бүх насаар хорих ял оноохыг хуулиар хориглодог байжээ.

Австрали Улс: XVIII зууны сүүлээс Их Британи гэмт хэрэгтнүүдийг шийтгэлийн нэг хэлбэр болгон Австрали руу илгээж эхэлсэн нь тус улсын хорих ялын тогтолцооны эхлэл болсон. Анхны ялтнууд 1788 онд ирсэн бөгөөд тэд шинэ колони байгуулах ажилд оролцож байв. Дараа нь муж бүр өөрийн онцлогт нийцүүлэн хорих ялын хууль тогтоомж, бодлогоо боловсруулсан.

Эдгээр улс орнуудын жишээнээс харахад хорих ялын тогтолцоо нь тухайн орны түүх, шашин, хууль эрх зүй, нийгмийн бодлоготой уялдан хувьсан өөрчлөгдөж ирсэн бөгөөд бүх насаар болон хугацаатай хорих ял зэрэг олон хэлбэрээр хөгжиж, зарим улсад хатуу шийтгэл давамгайлж байхад зарим нь нийгэмшүүлэх, нөхөн сэргээх чиглэлд илүү түлхүү төвлөрч байгааг харуулж байна.

Улс орнуудын ялын бодлого, үр нөлөө

Хорих ялын бодлого нь улс орон бүрийн хууль эрх зүйн тогтолцоо, соёл, шашны үнэт зүйлсээс хамааран ялгаатай хэрэгжиж ирсэн бөгөөд үр нөлөө нь ч өөр өөр байна.

Арабын орнууд (АНЭУ, Саудын Араб): Шариатын хуулийг голчлон баримталдаг эдгээр улсад гэмт хэрэгт хатуу, олон нийтийн өмнө шийтгэх бодлого давамгайлдаг. Цаазаар авах ял, ташуурдах, гар таслах зэрэг шийтгэл нь гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой ч хүний эрхийн байгууллагууд хатуу шүүмжилдэг. Сүүлийн жилүүдэд насанд хүрээгүй болон эмэгтэйчүүдэд бүх насаар хорих ял оногдуулахгүй байх зэрэг өөрчлөлтүүд орж, бодлого харьцангуй зөөлрөх хандлага ажиглагдаж байна.

Казахстан Улс: Эрх чөлөөг хязгаарлах болон хорих ялыг хослуулсан бодлого хэрэгжүүлдэг. Ялтнуудыг нийгмээс бүрэн тусгаарлахгүйгээр оршин суугаа газарт нь албадан ажил хийлгэх, хяналт шалгалт тогтоох нь дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, нийгэмд дасан зохицох боломж олгох чиглэлтэй.

Бразил Улс: 2019 оноос хорих ялын дээд хэмжээг 30 жилээс 40 жил болгож нэмэгдүүлсэн нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилготой боловч шоронгийн ачаалал, хүчирхийлэл, эрүүл ахуйн асуудал, халдварт өвчний тархалт зэргээс шалтгаалан хоригдлуудыг нийгэмшүүлэх үр нөлөө буурах, дахин гэмт хэрэг үйлдэх магадлал өсөх зэрэг сөрөг үр дагавар дагуулсан. Системийн эмзэг байдал, хоригдлуудын бүлэглэл хоорондын зөрчил ихэссэн нь бодлогын хэрэгжилтийг хүндрүүлж байна.

Шинэ Зеланд Улс: Цаазаар авах ялыг халж, бүх насаар хорих ял болон олон нийтийн ажил, гэрийн хорио зэрэг ял шийтгэлийг хослуулан хэрэглэх бодлого хэрэгжүүлдэг. Энэ нь хоригдлыг нийгэмд дахин нэгтгэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хорих ангийн ачааллыг бууруулахад чиглэдэг боловч дахин гэмт хэрэг үйлдэх хувь харьцангуй өндөр хэвээр байна.

Австри Улс: Ялын харьцангуй тогтвортой санкц, сонгох боломжтой ял шийтгэл, хугацаанаас нь өмнө суллах бодлого өргөн хэрэглэгддэг. Энэ нь хоригдлыг засарч хүмүүжих итгэл найдвар өгч, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх хандлагыг нэмэгдүүлдэг гэж үздэг.

Австрали Улс: Бүх насаар хорих ялтай ч ихэнх муж, нутаг дэвсгэрт тодорхой хугацааны дараа тэнсэн харгалзахгүйгээр суллах бодлогыг хэрэгжүүлдэг. Зарим мужид заавал хамгийн бага хугацаа тогтоодог бөгөөд энэ нь нийгмийн аюулгүй байдал, давтан гэмт хэрэгтэй тэмцэх зорилготой. Гэсэн хэдий ч муж бүрийн бодлого харилцан адилгүй учраас хорих ялын үр нөлөө нь өөр өөр байна.

Эдгээр жишээнээс харахад хорих ялын бодлого нь тухайн улсын нийгмийн үнэт зүйл, хууль эрх зүйн зарчимтай уялдаж хэрэгждэг. Хатуу шийтгэл давамгайлсан орнууд гэмт хэргийн зарим төрлийн гаралтыг бууруулж болох ч хүний эрхийн асуудлыг дагуулдаг. Харин нөхөн сэргээх, олон нийтийн ажил зэрэг зөөлөн бодлого хэрэгжүүлдэг улсад хорих ялын үр нөлөө нь нийгэмшүүлэх чиглэлд илүү төвлөрдөг боловч дахин гэмт хэрэг үйлдэхээс бүрэн сэргийлэхгүй байна.

Улс орнуудын ялын хэмжээ үр нөлөөнд хийсэн шинжилгээ

<i>Улс орон</i>	<i>Хорих ялын хэмжээ</i>	<i>Ялын үр нөлөө / бодлого</i>	<i>Эрх зүйн бүл, онцлог</i>
<i>АНЭУ (Арабын орнууд)</i>	Бүх насаар хорих; 3–15 жил (түр хугацаатай)	35 төрлийн гэмт хэрэгт бүх насаар хорих ял, нийт 64 төрлийн гэмт хэрэг хорих ялтай; хатуу шийтгэл давамгайлсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой	Исламын шариатын хуульд үндэслэсэн хатуу шийтгэл; эмэгтэйчүүд, 18-аас доош насныханд бүх насаар хорих ял оноохгүй байх өөрчлөлт орсон
<i>Казахстан</i>	6 сар–15 жил; онц хүнд гэмт хэрэгт 20 жил эсвэл бүх насаар хорих	Эрх чөлөөг хязгаарлах, нийгмээс бүрэн тусгаарлахгүйгээр оршин суугаа газарт албадан ажил хийлгэх бодлого хэрэгждэг	Эрүүгийн хуульд заасан хяналт, шалгалт; жирэмсэн, өндөр настанд тусгай журамтай
<i>Бразил</i>	Дээд хэмжээ 40 жил (2019 оноос; өмнө нь 30 жил)	Олон гэмт хэрэг нэгтгэсэн ч 40 жилээс хэтрэхгүй; шоронгийн ачаалал өндөр, дахин гэмт хэрэг үйлдэх хувь өндөр	Колоничлолын үеэс эхлэлтэй; хүний эрхийн нөхцөл сул
<i>Шинэ Зеланд</i>	Хүн амины хэрэгт бүх насаар, бусад гэмт хэрэгт 14 жил хүртэл	Цаазаар авах ялыг халсан; олон нийтийн ажил, гэрийн хорио зэрэг өөр төрлийн ялыг хослуулдаг; хорих ангийн ачаалал буурсан ч дахин гэмт хэрэг үйлдэх хувь харьцангуй өндөр	Бэлгийн хүчирхийлэлд 14 жилээс бүх насаар; нөхөн сэргээх бодлого давамгайлсан
<i>Австри</i>	Хугацаатай хорих 1 өдөр–20 жил; бүх насаар хорих ялыг 15 жил эдэлсний дараа суллах боломжтой	Харьцангуй тогтвортой санкц; хугацаанаас нь өмнө суллах бодлого өргөн хэрэглэдэг; засарч хүмүүжих боломж олгодог	20 нас хүрээгүй этгээдэд бүх насаар хорих ял оноохыг хориглоно
<i>Австрали</i>	Бүх насаар хорих ялтай ч ихэнхдээ 10–25 жилийн дараа тэнсэн суллах эрхтэй	Муж бүр өөр өөр бодлого хэрэгжүүлдэг; заримд заавал хамгийн бага хугацаа тогтооно; давтан гэмт хэрэгтэй тэмцэх зорилготой	Гэмт хэрэг хамгийн хүнд тохиолдолд бүх насаар хорих; хүүхдийн бэлгийн хүчирхийлэл зэрэгт хатуу бодлого баримталдаг

Арабын Нэгдсэн Эмират Улсад сүүлийн жилүүдэд хорих ялын бодлогыг шинэчилж, зөвхөн шийтгэхээс илүү нөхөн сэргээх, нийгэмшүүлэх чиглэлд түлхүү хандаж эхэлжээ. 2024 оны шинэ хуулиар жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхэдтэй эхчүүдийг тусгай нөхцөлд байлгах, хоёр нас хүртэлх хүүхдээ хамт байлгах эрх, тодорхой гэмт хэрэгт ялыг мөнгөн төлбөрөөр солих (“buy-out”) зэрэг нөхцөлүүдийг тусгасан нь өмнөх хатуу шийтгэлийн бодлогыг зөөлрүүлж байгааг харуулж байна. Гэвч хүний эрхийн байгууллагууд, тухайлбал Human Rights Watch, улс төрийн болон терроризмтой холбоотой хэргүүдэд олон хүнийг бүх насаар хорих ялаар шийтгэж буйг шүүмжилсээр байна.

Шинэ Зеландын хувьд хорих ялын бодлогыг олон нийтийн ажил, гэрийн хорио зэрэг хорихоос өөр арга хэмжээг нэмэгдүүлэх чиглэлд хөтөлсөн нь үр дүнгээ өгч, 2018 оны оргил үеийн 10 мянга давсан хоригдлын тоо 2021 он гэхэд 7700 орчим болж буурсан байна. Гэсэн хэдий ч дахин гэмт хэрэг үйлдэх хувь харьцангуй өндөр хэвээр байгаа нь ял шийтгэлийн системийн бусад хүчин зүйл (амьдралын нөхцөл, нийгмийн бодлого) нөлөөлж буйг харуулдаг.

Австралид 2024 оны байдлаар насанд хүрсэн хоригдлуудын тоо 44,403 болж, өмнөх оноос 6 хувиар өссөн нь шоронгийн хүн ам нэмэгдэж байгааг илтгэнэ. Мөн нийт хоригдлуудын 60 хувь нь өмнө нь ял эдэлж байсан хүмүүс байгаа нь дахин гэмт хэрэг үйлдэх асуудал өндөр

хэвээр байгааг харуулж байна. Энэ нөхцөлд шоронгийн дотор нөхөн сэргээх сургалтын хөтөлбөрүүд, эрт суллах бодлого, хүмүүнлэг бус ял шийтгэхгүй байх зэрэг шинэ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэлсэн нь хорих ялын бодлого өөрчлөгдөж байгаагийн илрэл юм.

Эдгээр жишээнээс харахад хорих ялын бодлого улс орнуудын дотоод хууль эрх зүйн шинэчлэл, хүний эрхийн шаардлага, нийгмийн өөрчлөлтөд хариу болгон өөрчлөгдөж байна. Хатуу шийтгэл давамгайлсан бодлогыг илүү нөхөн сэргээх, нийгэмшүүлэх чиглэлд шилжүүлэх хандлага Арабын Нэгдсэн Эмират, Шинэ Зеланд зэрэгт ажиглагдаж байгаа бол Австралид хорих ялын хүн ам өсөж, дахин гэмт хэрэг өндөр байгаа нь бодлогын хэрэгжилтэд сорилт хэвээр байгааг харуулж байна.

Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан Арабын Нэгдсэн Эмират, Саудын Араб, Казахстан, Бразил, Шинэ Зеланд, Австри, Австрали зэрэг улс орнуудын хорих ялын тогтолцоог харьцуулсан дүн шинжилгээгээр хорих ялын бодлого, хэмжээ нь тухайн улсын хууль эрх зүй, шашин, соёл, нийгмийн үнэт зүйлсээс шууд хамааралтай болохыг харуулж байна.

Хатуу шийтгэл давамгайлсан орнуудад (жишээлбэл, арабын зарим улс) гэмт хэргийн тодорхой төрлийн гаралт харьцангуй бага ч хүний эрхийн асуудал дагалддаг. Харин нөхөн сэргээх, олон нийтийн ажил зэрэг хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэдэг орнуудад (жишээлбэл, Шинэ Зеланд, Австри) хоригдлуудын нийгэмшилт, засарч хүмүүжих боломж нэмэгддэг боловч дахин гэмт хэрэг үйлдэхээс бүрэн сэргийлж чаддаггүй байна.

Сүүлийн жилүүдэд зарим оронд (АНЭУ, Шинэ Зеланд) хатуу шийтгэлээс нөхөн сэргээх, нийгэмшүүлэх бодлогод шилжих хандлага ажиглагдаж байгаа нь хорих ялын шинэчлэл, үр нөлөөг илүү эергээр тодорхойлох боломжийг нээж байна. Харин Австрали зэрэг улсад хорих ангийн хүн амын өсөлт, дахин гэмт хэрэг өндөр байгаа нь бодлогын хэрэгжилтэд сорилт хэвээр байгааг харуулж байна.

Санал

- Хорихоос өөр төрлийн ял шийтгэл – Монгол Улсад хорих ялын дэргэд олон нийтийн ажил, нөхөн сэргээх зэрэг сургалтын хөтөлбөрийг өргөн нэвтрүүлэх нь үр нөлөөтэй.
- Хорих ялын дээд хэмжээг олон улсын жишигт нийцүүлэх – Ял шийтгэлийн хугацаа, нөхцөлийг олон улсын сайн туршлагад нийцүүлэн тогтоох нь бодлогын үр дүнг сайжруулна.
- Шоронгийн нөхцөлийг сайжруулах, дахин гэмт хэргээс сэргийлэх – Хоригдлуудад боловсрол, сургалт, ажил эрхлэлтийн боломж олгож, суллагдсаны дараах нийгэмшлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Тусгай бүлгийн хорих ялын онцлог – Хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настанд хорих ялын тусгай журам тогтоох, нөхцөлд тохирсон хөнгөлөлт үзүүлэх нь хүний эрхийг хамгаалахад дөхөм болно.
- Бодлогын тогтвортой байдлыг хангах – Хорих ялын бодлогын өөрчлөлтийг хүний эрхийн олон улсын стандартад нийцүүлэх, үр нөлөөг тогтмол үнэлэх систем нэвтрүүлэх шаардлагатай.